

МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХАРИЛЦААНД БИЕ ДААН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

THE NECESSITY TO DETERMINE THE LEGAL STATUS OF SELF-EMPLOYED INDIVIDUALS IN LABOR RELATIONS IN MONGOLIA

Дэчинбэгзийн Отгонсүрэн*

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Pol. 1st Lt Dechinbegz Otgonsuren, lecturer, Private Law Department, Law and Social Sciences School, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: dechinbegzotgonsuren@gmail.com

Хураангуй: Монгол Улс дахь хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд зохицуулагдаагүй байгаа “бие даан хөдөлмөр эрхлэгч”-ийн эрх зүйн байдал, нийгэм эдийн засгийн баталгаа, хөдөлмөр эрхлэлтийг судлан дүгнэлт өгөх зорилго агуулсан. Хөдөлмөрийн харилцаанд зарим бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг тодорхойлон, эрх зүйн зохицуулалтыг хийсэн ч “Бие даан хөдөлмөр эрхлэгч”-ийн зохицуулалтыг орхигдуулсан бөгөөд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль” бусад хууль тогтоомжид дурдсан нэр томъёо, тавигдах үндсэн шаардлагын хүрээнд “Хувиараа хөдөлмөр эрхлэгч”-ийн ангилал нийцэхгүй байгаа тул “Бие даан хөдөлмөр эрхлэгч” -ийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд бие даан хөдөлмөр эрхэлж, эрсдэл нөхцлөө өөрөө биечлэн хариуцаж, түүнийхээ хариу төлбөрөөр амьжиргааныхаа үндсийг бүрдүүлдэг, судалгаа, бүртгэлд “ажилгүй”, “хувиараа” гэх тодотголтой иргэдийн нийгмийн харилцааг зохицуулахад эрдэмтэн судлаачдын анхаарлыг хандуулахад энэхүү өгүүлэл ач холбогдолоо өгнө гэж үзэж байна. Энэ талаарх судалгаа, дүгнэлт эрдэмтэн, судлаачдын бүтээлд одоогоор дурдагдаагүй байна.

Abstract: The aim is to examine the legal status, socio-economic guarantees and employment of “self-employed persons” who are not regulated in Employment Relations in Mongolia. Despite the definition and legal regulation of the employment of certain groups of citizens in labor relations, the regulation of “self-employed” was omitted, and the “Employment Support Act” does not correspond to the classification of “self-employed” within the framework of the terms and basic requirements mentioned in other legislation, there is a need to establish the legal regulation of “self-employed”. It is expected that this article will be useful for scientists and researchers to draw attention to the management of social relations between “unemployed” and “private” people in the employment relations, who are self-employed, personally responsible for their risks and their livelihood through their compensation. Research and conclusions on this matter have not yet been mentioned in scholarly works.

Түлхүүр үгс: Хөдөлмөр эрхлэлт, харилцаа, зохицуулагдаагүй, хувиараа.

Keywords: Employment, relations, unregulated, private.

Удиртгал

Хөдөлмөрийн онол нь хөдөлмөрийн үнэ цэнэ, зарцуулалтын

онолуудыг бий болгодог бол эдгээр онолууд нь эцсийн дүндээ эдийн засгийн онолыг бүрдүүлж хувь хүний хөгжил



Дэчинбэгз Отгонсүрэн



ХҮҮЛЬ САХИУЛАХ УРҮҮГ

хийгээд улс орны хөгжлийг тодорхойлох өргөн утга агуулгатай харилцаа байдаг. Иргэдийн хүсэл сонирхол хомсдолын онолд тулгуурлан хөдөлмөр эрхлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байдаг. Монгол Улс дэлхийн улс орнуудын нэгэн адил НҮБ-ын мэргэшсэн байгууллага болох ОУХБ-т /Олон улсын Хөдөлмөрийн байгууллага- International Labour Organization, ILO/ 1968 онд гишүүнээр элсэж, тус байгууллагын гэрээ, конвенцыг даган мөрдөж, дотоодын хууль тогтоомждоо тусган биелэлтийг ханган, тухайн харилцаанд төрийн хяналтыг тогтоон талуудын эрх ашгийг хамгаалан хөдөлмөрийн харилцаанд эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсээр ирсэн байна. Монгол Улс хувийн өмчийг дэмжсэн эдийн засгийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлээд 30 гаруй жил болж байна. Нийгэм хөгжиж, нээлттэй эдийн засгийн бодлого хүрээллээ тэлэх тутамд шинэ төрлийн ажил үйлчилгээ бий болж, хөдөлмөрийн харилцаа өргөжиж байдаг. Ардчилал, хүний эрх, хувийн өмч, өмчийн олон хэлбэр гэх мэт нэр томьёо бидэнд хэдий нь танил болсон үүнийг дагаад зэрэгцэн хөгжиж байгаа зүйл бол хөдөлмөрийн зах зээл юм. Монгол Улсын Үндсэн хуульд ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй, хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй (Үндсэн хууль, 1922) хэмээн заасан байдаг нь өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжуудын үндсэн эх сурвалж болж байдаг. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд “Бие даан хөдөлмөр эрхлэгч” буюу зар болон дуудлагаар, очиж хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг тодорхойлох нэр томьёо, эрх зүйн байдал, нийгэм эдийн засгийн баталгаа, төрөөс үзүүлэх хөнгөлөлт, боломж гэх мэт асуудлууд нь хэрхэн шийдэгддэг талаарх тодорхойгүй асуудлыг шинжлэх ухааны

үндэслэлтэйгээр тодруулах нь чухал юм. Үүний тулд дараах асуудалд анхаарал хандуулах хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Нэгдүгээрт: Бие даан хөдөлмөр эрхлэгчийн эрх зүйн байдлыг хууль тогтоомжид хэрхэн тодорхойлж, статистик судалгаанд дурдсан талаар судлан дүгнэх

Хоёрдугаарт: Гадаадын улс орнуудын туршлагад бие даан хөдөлмөр эрхлэгчийг хэрхэн тодорхойлж, нийгэм эдийн засгийн баталгааг хангаж байгааг судлан дүгнэх


Гуравдугаарт: Монгол Улс хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд цаашид бие даан хөдөлмөр эрхлэгчийн эрх зүйн байдлыг хэрхэн тодорхойлж, хөдөлмөрлөх эрх, нийгэм эдийн засгийн баталгааг хангах бодлого баримталж байгаа эсэхийг судлан дүгнэж эрх зүйн орчиныг сайжруулах шаардлагатай юм.

Үндсэн хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь нийгмийн олон талт харилцааны нэг хэсгийг зохицуулдгаараа бусад салбар эрх зүйгээс зохих ялгаа онцлогтой. Хөдөлмөрийн харилцаа нь өмчийн хэлбэрээс үл харгалзан бүх салбарыг хамран эрх зүйн үр дагавар бий болгож байдгаараа бусад салбар эрх зүйн харилцаанаас өргөн цар хүрээтэй байдаг. Хөдөлмөрлөх эрхийн харилцаанд оролцож байгаа нийт иргэдийн эрх, үүрэг, нийгэм хамгааллын асуудалд анхаарал хандуулан хөдөлмөрийн эрх зүйн харилцааны “Хөдөлмөрлөх эрх чөлөөг баталгаажуулах”, “Үл ялгаварлан гадуурхах” (Хөдөлмөрийн тухай хууль, 2021), суурь зарчмыг баримтлан хөдөлмөрийн харилцаан дахь эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгцээ бий болсон байна. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх насны иргэдийн 56.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байна гэсэн 2024 онд судалгаа гарсан байна (Үндэсний статистикийн хороо, 2024 он). Судалгааны дүнг дүгнэвэл үлдсэн хувь нь идэвхтэй ажил

хайгч, бүртгэлгүй, орлого тодорхойлох боломжгүй иргэд байна. Нийгмийн халамжийн тухай хуульд 3.1.2."нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн" гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг (Нийгмийн халамжийн тухай хууль, 2012) гэж хуульчилсан байна.



Загвар 1. Хөдөлмөрийн харилцааг хэрэгжиж байгаа өмчийн хэлбэрийн цар хүрээгээр нь схемээр тодорхойлсон нь

Монгол Улсад нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна. 2023 оны эхний арван сарын байдлаар 2.6 сая иргэн нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 39,500 хүнээр буюу 1.6 хувиар өссөн үзүүлэлт юм. (Билгүүн, 2023) 2023 оны нэгдүгээр сард нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын тоо 1.5 сая байсан бол, 2023 оны эхний хагас жилийн байдлаар энэ тоо 2.3 саяд хүрсэн байна. (Үндэсний статистикийн хороо, 2023)

Идэвхтэй ажил хайгч, бүртгэлгүй, орлого тодорхойлох боломжгүй 46.3 хувийн иргэдийн шалтгаан, нөхцөл, бодит тоон үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлоогүй тохиолдолд халамжийн сангаар дамжуулан халамжид хамрагдагчдын хувь хэмжээ өсөж, улсын

эдийн засаг, төсөвт ихээхэн хүнд дарамт болдог.

Монгол Улсын хууль тогтоомжид дараахь зүйл заалтуудад “хувиараа хөдөлмөр эрхлэгч”, “ажилгүй”, “бие даасан ажил гүйлгээ эрхлэгч иргэн” гэдгийг доорх байдлаар тодорхойлсон байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд 3.1.8.-д "хувиараа хөдөлмөр эрхлэгч" гэж дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлэн бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрээ хараат бусаар бие даан гаргадаг иргэнийг” (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 2011) гэж тодорхойлсон байна. Тухайн тодорхойлолтыг авч үзвэл



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ
ТОГТОМЖ



ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠰᠠᠬᠢᠭᠤᠯᠠᠬᠤᠢ


өмчийн хэлбэрийн хувьд өөрийн эрхлэх аж ахуйтай татварын албанд бүртгүүлсэн эрх эдэлж үүрэг хүлээх субъект байхыг илэрхийлсэн байна.

2. Мөн хуулийн 3.1.3."ажилгүй" гэж Төрийн албаны тухай хуульд заасан төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаагүй, түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах гэрээ (Иргэний хууль, 2002), тэдгээртэй адилтгах гэрээгээр ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхлээгүй байхыг... гэж заасан байна.
3. Татварын ерөнхий хуульд 6.1.43."бие даасан ажил гүйлгээ" гэж харилцан хамааралгүй этгээд хооронд хийсэн ажил гүйлгээг (Татварын ерөнхий хууль, 2019) гэж тодорхойлсон байна.

Тухайн эрх зүйн актуудаас үзэхэд хуулийг ойлгох, хэрэглэх, тайлбарлах ажиллагаанд нэр томьёо нэг мөр болж

чадаагүй байгааг харуулж байна. Хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан болон байгуулаагүй ажил хөдөлмөр эрхэлж байгаа бие даасан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг ажилтныг нийгэмд тодорхойлсон нэр томьёо байхгүй байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд зохицуулагдаагүй харилцаа байгааг харуулж байна. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид заасан “хувиараа хөдөлмөр эрхлэгч”, “ажилгүй”, “бие даасан ажил гүйлгээ” гэсэн тодорхойлолтоор бие даан хөдөлмөр эрхлэгчийг тодорхойлох боломжгүй юм.

Судалгаа, анкет бөглөх, бүртгэлд хамрагдах тохиолдолд “хувиараа” гэдэг бичилт хийдэг ч энэ нь тухайн этгээдийн үйл ажиллагааг тодорхойлсон албан ёсны тодорхойлолт, нийгэм эдийн засгийн баталгааг хангах, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн нэр томьёо болж чаддаггүй байна. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх насны иргэдийн 56.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа бол үлдсэн 43.6 хувийн хэдэн хувь (?) нь бие даан бүртгэлгүйгээр, статистик судалгааны дүнд хамрагдахгүйгээр хөдөлмөр эрхэлж байна гэдэг нь анхаарал татаж байна.



шийдвэрээ хараат бусаар бие даан гаргадаг


Загвар 2. “Хувиараа хөдөлмөр эрхлэгч”, “Бие даан хөдөлмөр эрхлэгч”-ийн ялгаатай болон ижил төсөөтэй шинж

ОХУ-ын иргэний хууль, хөдөлмөрийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эрх, үүргийг тодорхойлсон (Крицкая, 2024). Хувиараа хөдөлмөр эрхлэгчид нь аж ахуйн нэгж байгуулахгүйгээр бие даан ажил, үйлчилгээ үзүүлдэг иргэд гэж тодорхойлсон байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид татварын албанд бүртгүүлж, татвар төлөгчийн хувиар албан ёсны статус авах, гэм хорыг арилгах, сайн дураараа нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдах зэрэг заалт нь манай улсад мөрдөгддөг хууль тогтоомжтой адил төстэй байна.

ОХУ-ын Хөдөлмөрийн хуулийн хүрээнд эдгээр хүмүүсийг ердийн ажилтантай адилтгаж үзэхгүй бөгөөд үйл ажиллагааныхаа шинж чанараас хамааран өөр зохицуулалт үйлчилдэг. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нь ОХУ-ын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хууль эрх зүйн орчин нь уян хатан, дэмжлэг үзүүлэх чиглэлтэй байдаг байна. Манай улсаас онцлог ялгаа нь Хөдөлмөрийн тухай хуулиараа зохицуулагдаагүй харилцааг өөр бие даасан эрх зүйн зохицуулалт үйлчлэхээр заасан байна. Мөн ажил үйлчилгээ эрхлэх харилцааг зохицуулахдаа

Хөдөлмөрийн гэрээнээс тусдаа бие даасан үйлчилгээний гэрээ байхаар заажээ. (Үйлчилгээ үзүүлэх гэрээ). Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгчийг тодорхойлохдоо жилийн 2.4 сая рублиас хэтрээгүй байхыг ойлгохоор заажээ. Тиймээс хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэнийг орлого олох үйл ажиллагаа эрхэлдэг, хувиараа бизнес эрхлэгчээр бүртгүүлээгүй субъект гэсэн тодорхойлолтыг албан ёсны эрх зүйн түвшинд хуулийн дагуу норматив эрх зүйн актад тусгасан бөгөөд нэр томьёоны хувьд тодорхой болсноор цаашид эрх зүйн орчныг нарийвчлах боломжтой болсон (Александрович, 2022) гэсэн байна.

Хөдөлмөрийн эрх зүй бол ажилтнуудын хөдөлмөрийн болон түүнээс уламжлан үүсэх харилцааг зохицуулагч эрх зүйн хэм хэмжээний нийлбэр, систем бөгөөд хөдөлмөрийн эрх зүйн шинжлэх ухаан нь салбар эрх зүйн хэм хэмжээний мөн чанар, үүрэг, түүний зохицуулах зүйл болсон нийгмийн харилцааг судлах, үүнийхээ дагуу Монгол Улсын Хөдөлмөрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох үзэл баримтлал, үндэслэлийг боловсруулах зорилго бүхий хууль зүйн шинжлэх ухааны нэг салбар юм.



Загвар 3. Бие даан хөдөлмөр эрхлэгчийн онцлог



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠢᠭᠠᠨ ᠤᠯᠤᠰ

Нийтлэг чанартай акт бол ажилтнуудын хөдөлмөрийг нэгдмэлээр зохицуулах төрийн бодлогын илрэл бөгөөд улс ардын аж ахуйн бүх салбарт буюу бүхий л хөдөлмөрийн харилцааг зохицуулна (Баасан, 2021). Энэ нь Монгол улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэлтийн бүхий л харилцааг Хөдөлмөрийн тухай хууль тодорхойлон заахыг илэрхийлсэн байна.

“Бие даан хөдөлмөр эрхлэгч” иргэдийн гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээний онцлогоос хамаарч хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээнд хамааруулж амаар гэрээ байгуулсан гэж үзэх үндэслэлтэй ч хөдөлмөр эрхлэлтийн харилцааны аль хэсэгт хамааруулан

төрөөс ямар, дэмжлэг эдлэх нь тодорхойгүй байна. Монгол Улс нь хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээг бие даан хөдөлмөр эрхлэгч иргэдийн хөдөлмөрийн харилцаанд хэрэглэн тухайн харилцаанд гэм хор үүссэн тохиолдолд хохирлыг хэрхэн барагдуулах талаарх асуудалд нотолгооны баримтын хэмжээнд хүлээн зөвшөөрдөг ч хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээ нь тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэж буй бие даан хөдөлмөр эрхлэгчийг тодорхойлох нэр томьёо, эрх зүйн байдал, нийгэм эдийн засгийн баталгаа, төрөөс үзүүлэх нийгэм хамгааллын үндсэн асуудлуудад хамаардаггүй байна.

д/д	Судалгааны асуумж	БГД дүгээр хороо		
		1	2	3
1	Таны харьяа хороо дүүрэг дэх хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл	a		b
		Ажилгүй-32%		Хувиараа ямар нэгэн хөдөлмөр эрхэлдэг-68%
2	Та идэвхтэй ажил хайгч мөн үү	a	b	c
		Тийм-37%	Үгүй-12%	Би өөрийн бие даасан ажилтай-51%
2	Таны орлогын эх үүсвэр	a	b	c
		Өрхийн гишүүдийн орлого-23	Хувиараа хийдэг ажил-61.2%	Бусад-15.8%
3	Та хэрвээ бие даан хөдөлмөр эрхэлдэг бол орлого тогтмол байдаг уу	a	b	c
		Ажил олдох эсэхээс хамаардаг-49%	Тодоройлох боломжгүй-34.3%	Орлого байхгүй-16.7%
4	Тогтмол ажлын байртай байхыг илүүд үздэг үү ?	a	b	c
		Тийм-38%	Үгүй-1.4%	Бие даан хөдөлмөрлөх нь давуу байдаг-60.6%
5	Та бие даан хөдөлмөр эрхэлдэг бол хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг хэрхэн хангадаг вэ	a	b	c
		Өөрөө бүх эрсдэлээ тооцож хангадаг-67.3%	Ажил олгогчтой харилцан ярилцаж хангадаг-8%	Ерөнхийд нь мэддэг-24.7%
6	Та бие даан хөдөлмөр эрхэлдэг багаж тоног төхөөрөмжийн асуудлаа хэрхэн шийддэг вэ?	a	b	c
		Өөрөө бэлтгэдэг-61.6%	Ажил олгогччоор гаргуулдаг-11.3%	Хариулах боломжгүй байна-27.1%
7	Та нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал төлдөг үү	a		b
		Тийм-7.1%		Үгүй-92.9%
8	Таны өрхийн ам бүлийн тоо	a	b	c
		(1-3)-28%	(4-6)- 39%	7 ба түүнээс дээш-33%
9		a	b	c


	Та хороо дүүргээс ямар нэг хөдөлмөр эрхлэлтгүй холбоотой халамж үйлчилгээ, сургалтад хамрагдаж байсан уу?	Сургалтад хамрагдаж байсан- 5.8%	Тоног төхөөрөмжийн тусалцаа авч байсан-0.4%	Үгүй-93.8%
10	Та бие даан хөдөлмөр эрхлэх үедээ гэмтэл бэртэл авч байсан уу? Тийм бол тэр үед эмчилгээний зардлыг хэрхэн шийдвэрлэж байсан бэ?	Тийм-38 иргэн хариулсан Түүнээс		
		a	b	c
		Өөрөө бүх зардлаа хариуцсан- 81%	Нийгмийн даатгалын хүрээнд нөхөн олговор авч байсан-7.6%	Ажил олгогч зарим хэсгийг шийдвэрлэсэн- 11.4%

Хүснэгт 1. Нийслэлийн БГД-ийн ... дүгээр хорооны “ажилгүй”, “хувиараа” гэх бүртгэлд бүртгэгдсэн 23-45 насны 123 иргэний дунд зохион байгуулсан судалгааны дүн

Дээрх судалгааны дүнгээс харахад ажилгүй гэх бүртгэлтэй ч хувиараа гэсэн нэрийн дор иргэд хөдөлмөрийн харилцаанд бие даан оролцдог ч тэдний эрх ашиг, хөдөлмөрлөх эрх, нийгэм эдийн засгийн баталгааны асуудалд төрийн бодлого, зохицуулалт дутагдаж байгааг илэрхийлж байна.

Бие даан хөдөлмөр эрхлэгчид төрөл бүрийн салбарт хөдөлмөр эрхэлж байна. Жишээ нь: Боловсролын чиглэлээр гэрийн багш, барилгын чиглэлээр ахуйн зориулалтын байшин барих, барилгын засал чимэглэл, газар

шорооны ажил, автомашин засвар, дуудлагын жолооч гэх мэтчилэн өөрт байгаа багаж хэрэгсэл, туршлага, ур чадвараа ашиглан зар болон дуудлагаар ажил үйлчилгээ эрхэлж байгаа иргэдийн хөдөлмөрийг тодорхойлох хууль ёсны нэр томъёотой болгож хөдөлмөрийн харилцаанд эрхийг нь хангаж, зохицуулалт хийх нь тодорхой бүлгийн иргэдийн амьжиргааг баталгаажуулах замаар нийгмийн халамжид хамрагдагчдын хувь хэмжээг бууруулах боломжтой юм.



Загвар 4. Хөдөлмөрийн харилцаанд зохицуулагдсан харилцаа ба зохицуулалт шаардагдаж байгаа харилцаа

Дүгнэлт

“Бие даан хөдөлмөр эрхлэгч”-ийг цаашид хөдөлмөрийн эрх зүйн харилцааны судлагдахуун болгож,

бүртгэл, татвар, даатгал, нийгмийн халамж тусламж үйлчилгээнд хэрхэн яаж хамруулах зэрэг олон асуудлууд нь төрөөс зохицуулалт хүлээж байгаа



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

бөгөөд нэр томьёо тодорхой болсоноор тухайн асуудлуудыг эрх зүйн социологийн үүднээс судлан илрүүлэх хэрэгцээ шаардлага бий болно.

“Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд өөртөө шийдвэр гарган, ажил олгогчтой хүсэл зоригийн үндсэн дээр тохиролцоонд хүрч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг ханган, орлогоо тодорхойлох боломжгүй, ажлын дадлага туршлага ур чадвараа хөгжүүлэн амьжиргаагаа дэмжиж, өөртөө туслан ажлын байр бий болгож хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй, хөдөлмөр эрхлэгч иргэнийг “Бие даан хөдөлмөр эрхлэгч” гэнэ хэмээн тодорхойлж, жилийн орлого нь сарын цалингын доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлэн түүнээс ихгүй байх гэх мэтчилэн зааж эрх зүйн орчиныг тодорхойлж болох юм.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд ганцаараа болон бусадтай бие даан хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцож түүний хариу төлбөр болох ажил гүйцэтгэсэн орлогоороо гэр бүл, ахуй нөхцөл, нийгэм эдийн засгийн баталгаагаа хангаж, улс орны эдийн засагт тодорхой хувь нэмрээ оруулж байгаа иргэдийг анхааран үзэж, эрх зүйн зохицуулалтыг нь боловсронгуй болгох шаардлагатай юм. Бие даан хөдөлмөр эрхлэгчийн эрх зүйн байдлыг тодорхой болгосноор доорх нөхцөлүүд бий болж эрх зүйн хэм хэмжээ нийгмийн харилцааг зохицуулах үндсэн үүргээ гүйцэтгэнэ гэж дүгнэж байна.

Санал

- “Бие даан хөдөлмөр эрхлэгч”-ийг “хувиараа хөдөлмөр эрхлэгч”, “ажилгүй” гэх нэр томьёоноос ялган авч үзэж, статистик тоон үзүүлэлтийг бодитоор тооцон гаргах, судалгаанд дурдагдсан 46.3 хувийг бүрдүүлж байгаа иргэдийн хэдэн хувь нь “Бие даан хөдөлмөр эрхлэгч” ангилалд хамрах иргэн байгааг

тодорхойлон, ажиллах хүчний нөөц, нийгэм хамгааллын бодлогыг бодит үзүүлэлтэд тулгуурлан тодорхойлох.

- Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд нэмэлтээр “Бие даан хөдөлмөр эрхлэгч” гэсэн нэр томьёог оруулах нь тэдгээр иргэдийн эрх зүйн байдлыг тодорхойлох замаар зарим бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн ангилалд багтаан зохицуулалт хийснээр хүний эрх, эрх чөлөөг ханган, хэрэгжүүлсэн эрх зүйн хийдэлгүй нийгмийн харилцааг бүрэн зохицуулах хүчин чадалтай нийтлэг эрх зүйн акт болно. Нийгмийн харилцааг зохицуулах үндсэн үүргийнхээ хувьд нийтэд ойлгомжтой хүртээмжтэй байхын тулд нэр томьёо салаа утгагүй бусад эрх зүйн акт, хууль тогтоомжтой зөрчилдөхгүй нэг мөр ойлголт хэрэглээнд нэвтэрч ашиглах.
- “Бие даан хөдөлмөр эрхлэгч” иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд дахь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, нийгэм хамгааллын үндсэн асуудлууд нь төрөөс дэмжих бодлогын хүрээлэлд оруулж хувь хүн, өрх гэр бүл, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулах төдийгүй чинээлэг дунд давхаргынхныг бүрдүүлэхэд ахиц дэвшил бий болгоно гэж үзэж байна.

Ашигласан материал

Александрович, Ш. С. (2022). *Теория труда : учебник*. Москва. <https://e-univers.ru/upload/iblock/70d/fvus5asekeqn452188qm2h8no075rt8p.pdf> f Гаргасан

Баасан, Л. (2021). *Хөдөлмөрийн эрх зүй: ерөнхий анги*. Улаанбаатар.

- Билгүүн, Б. (2023). *Нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо өмнөх мөн үеэс 39,500-аар нэмэгджээ*. ikon.mn: <https://ikon.mn/n/30b2>-ээс Гаргасан
- Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: №07, 32 дугаар бүлэг 359 дүгээр зүйл. (Улсын их хурал 2002).
- Крицкая, М. (2024). *На что рассчитывать самозанятым в 2025 году*. Контур журнал: <https://kontur.ru/articles/4818>-ээс Гаргасан
- Нийгмийн халамжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: №08 (Улсын их хурал 2012).
- Татварын ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: №226, 1.43-р зүйл. (Улсын их хурал 2019).
- Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1 (Улсын их хурал 1922).
- Үндэсний статистикийн хороо. (2023). *ҮСХ:Нийгмийн халамжийн*

үйлчилгээнд хамрагдчдын тоо. Ulaanbaatar News LLC: <https://ubn.mn/p/38308>-ээс Гаргасан

- Үндэсний статистикийн хороо. (2024). *Албан бус хөдөлмөр эрхлэгчид, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, хүйс, бүс, аймаг, нийслэлээр, жилээр*. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://www.1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_082V7-ээс Гаргасан
- Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: №31, Ерөнхий анги: дугаар зүйл 5.1.2 (Улсын их хурал 2021).

Судалгааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн Нийслэлийн БГД-ийн ... хорооны засаг дарга Гинжхуягийн Жаргалсайхан таньд болон танай хамт олонд ажлын өндөр амжилт хүсье.



Дотоод Ажлын Яам